

## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Өлгий хот	Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
2024 он	“Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа Утас:99075818 Цахим хаяг:asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ЦЭНГЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
А.АНАРГУЛ ТАНАА

2024.02.23 № 201  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэрлэгийн 2023 оны жилийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

### Аудитын гол асуудал

Цэцэрлэгийн 2023 оны жилийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал гараагүй.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторовын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402286

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>26,124,414.18</u></b>	<b><u>113,848,346.61</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	13,976,697.18	103,559,854.11
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	13,976,697.18	103,559,854.11
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	13,976,697.18	103,559,854.11
31211	Төрийн сангийн харилцах	13,976,697.18	103,559,854.11
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	12,147,717.00	10,288,492.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,147,717.00	10,288,492.50
35410	Бичиг хэргийн материал	2,217,250.00	1,857,050.00
35420	Аж ахуйн материал	4,362,971.00	4,362,971.00
35440	Түлш, шатах тослох материал	27,000.00	27,000.00
35450	Барилгын засварын материал	289,000.00	35,000.00
35460	Хүнсний материал	4,222,096.00	633,371.50
35470	Бусад хангамжийн материал	1,029,400.00	3,373,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>864,808,717.41</u></b>	<b><u>860,263,468.21</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	864,808,717.41	860,263,468.21
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	859,132,717.41	853,164,229.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	919,356,399.93	934,356,399.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(85,768,145.58)	(107,109,531.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,987,666.90	28,973,666.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,506,420.76)	(20,764,250.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,192,240.00	33,192,240.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,129,023.08)	(15,484,295.16)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,676,000.00	7,099,239.00
39301	Програм хангамж		1,423,239.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,676,000.00	5,676,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>890,933,131.59</u></b>	<b><u>974,111,814.82</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>-</u></b>	<b><u>432,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	432,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	432,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	432,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	432,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>890,933,131.59</u></b>	<b><u>973,679,814.82</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	890,933,131.59	973,679,814.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,676,000.00	5,676,000.00
51101	Өмч: - төрийн	5,676,000.00	5,676,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	882,448,993.13	965,195,676.36
51210	Өмнөх үеийн үр дүн	(8,484,138.46)	882,493,302.13
51220	Тайлант үеийн үр дүн	890,933,131.59	82,702,374.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,808,138.46	2,808,138.46
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>890,933,131.59</u></b>	<b><u>974,111,814.82</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,303,594,621.61</b>	<b>627,601,039.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>899,099,530.61</b>	<b>20,779,239.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	899,099,530.61	20,779,239.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	888,723,977.61	20,779,239.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	10,375,553.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>404,495,091.00</b>	<b>606,821,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	365,014,600.00	589,430,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,014,600.00	589,430,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,376,991.00	17,391,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,376,991.00	17,391,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>412,661,490.02</b>	<b>544,898,664.77</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,661,490.02</b>	<b>544,898,664.77</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	412,557,990.02	544,853,548.77
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	294,732,693.82	386,792,563.07
210101	Үндсэн цалин	242,302,593.82	273,975,386.62
210102	Нэмэгдэл	45,118,600.00	95,440,938.72
210104	Урамшуулал	7,311,500.00	17,376,237.73
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,181,300.00	58,505,800.00
210201	Тэтгэврийн даатгал	25,632,800.00	39,784,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,887,100.00	4,680,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,309,800.00	3,744,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	577,300.00	935,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,774,300.00	9,361,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,854,420.00	17,090,393.00
210301	Гэрэл, цахилгаан	1,816,920.00	2,913,778.00
210302	Түлш, халаалт	9,822,900.00	13,652,752.00
210303	Цэвэр, бохир ус	214,600.00	523,863.00
2105	<b>Нормативт зардал</b>	35,121,266.00	45,481,804.50
210502	Хоол, хүнс	35,121,266.00	45,481,804.50
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	383,800.00	539,000.00
210604	Урсгал засвар	383,800.00	539,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	814,000.00	750,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	750,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,470,510.20	35,693,988.20

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,815,900.00	7,596,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,739,350.00	2,143,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,915,260.20	25,954,488.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	103,500.00	45,116.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	103,500.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	45,116.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,116.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>890,933,131.59</u></b>	<b><u>82,702,374.23</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>890,933,131.59</u></b>	<b><u>82,702,374.23</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>404,495,091.00</u></b>	<b><u>606,821,800.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>404,495,091.00</b>	<b>606,821,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	365,014,600.00	589,430,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	365,014,600.00	589,430,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	103,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	103,500.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,376,991.00	17,391,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,376,991.00	17,391,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>390,518,393.82</u></b>	<b><u>516,608,643.07</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>390,518,393.82</b>	<b>516,608,643.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>390,414,893.82</b>	<b>516,607,836.07</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	294,732,693.82	386,792,563.07
210101	Үндсэн цалин	242,302,593.82	274,177,672.62
210102	Нэмэгдэл	45,118,600.00	95,238,652.72
210104	Урамшуулал	7,311,500.00	17,376,237.73
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,181,300.00	58,505,800.00
210201	Тэтгэврийн даатгал	25,632,800.00	39,784,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,887,100.00	4,680,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,309,800.00	3,744,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	577,300.00	935,900.00

210205	Эрүүл мэндийн даатгал	5,774,300.00	9,361,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,728,480.00</b>	<b>17,090,393.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,816,920.00	2,491,200.00
210302	Түлш, халаалт	9,696,960.00	12,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	214,600.00	1,999,193.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,869,020.00</b>	<b>41,893,080.00</b>
210502	Хоол, хүнс	31,869,020.00	41,893,080.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>814,000.00</b>	<b>750,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	750,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,789,400.00</b>	<b>11,276,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,509,400.00	9,026,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,280,000.00	2,249,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>103,500.00</b>	<b>807.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>103,500.00</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>807.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	807.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>13,976,697.18</u></b>	<b><u>90,213,156.93</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>630,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>630,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>630,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	630,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-</u></b>	<b><u>(630,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>13,976,697.18</b>	<b>89,583,156.93</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>13,976,697.18</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>13,976,697.18</b>	<b>103,559,854.11</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,676,000.00	2,808,138.46	-8,484,138.46		0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,676,000.00</b>	<b>2,808,138.46</b>	<b>-8,484,138.46</b>	<b>0.00</b>	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			890,933,131.59		890,933,131.59
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,676,000.00</b>	<b>2,808,138.46</b>	<b>882,448,993.13</b>	<b>0.00</b>	890,933,131.59
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,676,000.00</b>	<b>2,808,138.46</b>	<b>882,448,993.13</b>	<b>0.00</b>	890,933,131.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			44,309.00		44,309.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,676,000.00</b>	<b>2,808,138.46</b>	<b>882,493,302.13</b>	<b>0.00</b>	890,977,440.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			82,702,374.23		82,702,374.23
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,676,000.00</b>	<b>2,808,138.46</b>	<b>965,195,676.36</b>	<b>0.00</b>	973,679,814.82

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	364,200,600.00	350,223,902.82	620,797,693.00	517,237,836.07
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	364,200,600.00	350,223,902.82	620,797,693.00	517,237,836.07
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	364,200,600.00	350,223,902.82	620,797,693.00	517,237,836.07
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	272,494,600.00	270,503,682.82	486,039,100.00	386,792,563.07
210101	Үндсэн цалин	217,987,600.00	218,073,582.82	315,494,700.00	274,177,672.62
210102	Нэмэгдэл	47,195,500.00	45,118,600.00	152,451,300.00	95,238,652.72
210104	Урамшуулал	7,311,500.00	7,311,500.00	18,093,100.00	17,376,237.73
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,061,800.00	34,061,800.00	58,505,800.00	58,505,800.00
210201	Тэтгэврийн даатгал	23,162,100.00	23,162,100.00	39,784,300.00	39,784,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,724,900.00	2,724,900.00	4,680,300.00	4,680,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,180,000.00	2,180,000.00	3,744,300.00	3,744,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	544,900.00	544,900.00	935,900.00	935,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,449,900.00	5,449,900.00	9,361,000.00	9,361,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	-	17,090,393.00	17,090,393.00
210301	Гэрэл, цахилгаан			2,491,200.00	2,491,200.00
210302	Түлш, халаалт			12,600,000.00	12,600,000.00
210303	Цэвэр, бохир ус			1,999,193.00	1,999,193.00
2105	<b>Нормативт зардал</b>	43,854,800.00	31,869,020.00	46,206,400.00	41,893,080.00
210502	Хоол, хүнс	43,854,800.00	31,869,020.00	46,206,400.00	41,893,080.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	-	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар			300,000.00	300,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	750,000.00	750,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			750,000.00	750,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,789,400.00	13,789,400.00	11,906,000.00	11,906,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,509,400.00	8,509,400.00	9,656,100.00	9,656,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,280,000.00	5,280,000.00	2,249,900.00	2,249,900.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	365,014,600.00	365,014,600.00	606,821,800.00	606,820,993.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	365,014,600.00	365,014,600.00	589,430,600.00	589,430,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	365,014,600.00	365,014,600.00	589,430,600.00	589,430,600.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	17,391,200.00	17,390,393.00
132001	Орон нутгийн төсвөөс			17,391,200.00	17,390,393.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				13,976,697.18
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				103,559,854.11

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус цэцэрлэг нь 2023 онд “Хүүхдийн онцлогт тохирсон хөгжлийг дэмжиж хүүхэд сурах таатай орчин бүрдүүлж, сургалтын чанар, үр дүнд ахиц гаргах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх
- Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих
- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлэх
- 2-5 настай хүүхдийг СӨБ-д 100% хамруулна. Тойрогт хамрагдаагүй алслагдсан багуудын 5 настай хүүхдүүдэд дасгал даалгавар гарын авлага бэлтгэж багын Засаг дарга нартай хамтран хүүдүүдийг бүрэн хамруулам ажиллах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүлэгт тэгш хамруулж, тусгай хөтөлбөр төлөвлөгөө гаргаж тулж ажиллах
- Ажлын байранд багшийн тасралтгүй хөгжих боломжийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх
- “Сайн хичээл үйл ажиллагаа”, “Багш солилцоо” хөтөлбөрүүдийг аймаг сумуудын хэмжээнд зохион байгуулах зэрэг зорилтууд байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83.2 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,976.70	103,559.85	89,583.16
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	12,147.72	10,288.49	(1,859.22)
Үндсэн хөрөнгө	864,808.72	860,263.47	(4,545.25)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>890,933.13</b>	<b>974,111.81</b>	<b>83,178.68</b>
Өр төлбөр	-	432.00	432.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	890,933.13	973,679.81	82,746.68
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>890,933.13</b>	<b>974,111.81</b>	<b>83,178.68</b>

Мөнгөн хөрөнгө оны эцэст 103.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 89.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 99.0 сая төгрөг нь цалингийн зардлаас, 4.3 сая төгрөг нь хоолны зардлаас, 7.7 сая төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардлаас, 3.7 сая төгрөг үдийн цайны зардлаас зардлаас үлдсэн мөнгө байна.

Бараа материал данс оны эцэст 10.3 сая төгрөг болж оны эхнээс 1.8 төгрөгөөр буурсан байна. Бичиг хэргийн материал 1.9 сая төгрөг, аж ахуйн материал 4.4 сая төгрөг, хүнсний материал 0.6 сая төгрөг, түлш 0.03 сая төгрөгийн, барилгын засварын материал 0.03 сая төгрөг, бусад хангамжийн материал 3.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 860.3 сая төгрөг болж 4.5 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 0.6 сая төгрөг, хандиваар авсан 20.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 25.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эцэст 0.4 сая төгрөгийн бусад зардлын өглөгтэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 973.7 сая төгрөг болж 82.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 82.7 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 401.0 сая, орон нутгийн төсвөөс 17.4 сая, нийт зарлагыг 418.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 381.6 сая төгрөгөөр хянаж, 19.4 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 239.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 620.8 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 17.4 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 603.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 17.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 620.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 499.8 сая, орон нутгийн төсвөөс 17.4 сая нийтдээ 517.2 сая төгрөгийн санхүүжилт авч, 14.0 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 517.2 сая төгрөг буюу 83.1 хувьтай буюу 103.6 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Эрүүл мэндийг дэмжих	81605	1,125.00	1,125.00	-	100.0%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	81807	46,206.40	41,893.08	4,313.32	90.7%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	2,343.70	2,343.70	-	100.0%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны	81823	1,125.00	1,125.00	-	100.0%
5	Боловсролын стандарт, сургалты	81834	335,959.80	269,826.71	66,133.09	80.3%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	81835	216,647.40	183,533.95	33,113.45	84.7%
7	Барилгын тогтмол зардал	80111	17,391.20	17,390.39	0.81	100.0%
	Нийт дүн		620,798.50	517,237.84	103,560.66	83.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 62.7 сая төгрөгийн бараа материал, 0.6 сая төгрөг үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэнгэл сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 13 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Ц.Оюунтуул, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 412.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цэнгэл сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үйлчилгээний ажилчдын ур чадварыг үнэлж ажиллах 1 албан өгөгдсөнийг давтан шалгахад хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1		1		100%
Зөвлөмж					
Нийт дүн	1		1		100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

### АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 16.0 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 16.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

#### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 16.0 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн сангаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	16 000.0					1	16 000.0				
Дүн	1	16 000.0					1	16 000.0				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		
			Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								